



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 21 өдөр

Дугаар A/15

Бор-өндөр сум

「Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар,
аюулгүй байдлын алба томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Монгол улсын нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны MNS5095:2017 стандарт, Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны “Дүрэм батлах тухай” 116/A/565 тоот тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эмнэлгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албыг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга:	Э.Болормаа	Чанарын менежер
Нарийн бичиг:	М.Цэцэгмаа	ХААБ ажилтан
Гишүүд:	Д.Батсүх	Хэвтэн эмчлүүлэх 1 тасгийн эрхлэгч
	Н.Бадамханд	Хэвтэн эмчлүүлэх 2 тасгийн эрхлэгч
	О.Мөнхцэцэг	Хүлээн авах оношзүйн тасгийн эрхлэгч
	Т.Баярчимэг	Амбулатори, захиргаа аж ахуйн тасгийн эрхлэгч
	Э.Минжинсор	Эм зүйч

2. Байгууллагын тусламж үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоонд нийцүүлэн чанарыг тасралтгүй сайжруулах, үйл ажиллагааг зохион байгуулах, чанар, эрсдэл, үйлчлүүлэгчийн авулгүй байдалд хяналт тавих, дэмжин туслах, арга зүйн зөвлөгөө өгч, зохицуулалт хийж ажиллахыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын гишүүдэд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд багаа удирдан чиглүүлж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг багийн дарга (Э.Болормаа)-д даалгасугай.

ДАРГА



А.БАТБААТАР